

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2022 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр
Хурал хуралдсан газар: Монголын МСС-гийн “Туул” хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)-ийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлаар дор дурдсан 8 асуудалтай танилцаж хэлэлцэн харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

Нэгдүгээр асуудал. Монголын МСС-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг батлав.

Хоёрдугаар асуудал. Компакт гэрээний Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд Засгийн газрын санхүүжилт, татварын хуваарьтай холбогдуулан МСК-аас ирүүлсэн өөрчлөлтийн тухай МСК-ын саналтай танилцаж, уг саналыг Сангийн яам болон холбогдох дээд түвшний байгууллагад танилцуулж, 2023-2025 оны төсөвт тусган шийдвэрлүүлэх чиглэлээр зөвшилцөн ажиллаж, МСК-д танилцуулж, албан ёсны зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирал /интерим/-д даалгав.

Гуравдугаар асуудал. Монголын МСС-ийн 2022 оны 4 дүгээр улирлын Санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг батлав.

Дөрөвдүгээр асуудал. Монголын МСС-ийн 2022.10.01-нээс 2023.09.30-ны хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлав.

Тавдугаар асуудал. Монголын МСС-ийн Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтийн төслийг батлав.

Зургадугаар асуудал. Монголын МСС-ийн шинээр томилогдсон Хуулийн ерөнхий зөвлөлтэй танилцав.

Долдугаар асуудал. Монголын МСС-ийн 2022 оны 3 дугаар улирлын ажлын төлөвлөгөөний биелэлтийн явц болон Усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл, Хаягдал ус дахин боловсруулах төсөл, мөн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хэрэгжилтийн явцтай танилцав.

Наймдугаар асуудал. Далайван хөндлөнгийн хараат бус аудитын тайлантай танилцав.